

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
АВТО ТЭЭВРИЙН ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ Б.ЦЭНДСҮРЭНГИЙН
2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д / д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
Зорилт 1. “Салбарын хууль тогтоомж, стандарт, норм, нормативын хэрэгжилтэд хяналт тавих, эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлэх”							
1	Арга хэмжээ 1.1. Автотээврийн салбарын эрсдэлийн шалгуур үзүүлэлтүүдийг шинэчлэн боловсруулахад санал өгөх.	Шалгуур үзүүлэлтийн тоо	2024 онд 1 санал хүргүүлсэн.	Шалгуур үзүүлэлтийг шинэчлэн боловсруулахад 1 санал өгсөн байна.	Хугацаа болоогүй	2025.06.02 2025.10.31	0
2	Арга хэмжээ 1.2. Автотээврийн салбарын байгууллагуудын объект, үйл ажиллагаанд эрсдэлийн үнэлгээ хийж, хяналт шалгалтын төлөвлөгөө боловсруулж, ЗТХЯ-ны Салбарын хяналтын газарт хүргүүлэх.	Эрсдэлийн үнэлгээ хийсэн байгууллага, 90-ээс багагүй. ЗТЯ-ны СХГ-т хяналт шалгалтын төлөвлөгөөг хүргүүлсэн байна.	2024 онд нийт 52 объектод эрсдлийн үнэлгээ хийсэн. -ЗТЯ-нд хяналт шалгалтын төлөвлөгөөг хүргүүлсэн.	Нийт 52-оос багагүй объектод эрсдлийн үнэлгээ хийсэн байна. ЗТХЯ-ны СХГ-т 2026 оны хяналт шалгалтын төлөвлөгөөг боловсруулж хүргүүлсэн байна.	Хугацаа болоогүй	2025.06.02 2025.11.30	0
3	Арга хэмжээ 1.3. Автотээврийн салбарын хяналт шалгалтад ашиглах хяналтын хуудсыг	-Хяналтын хуудасны тоо	3 хяналтын хуудсанд өөрчлөлт оруулахаар 4	3-аас доошгүй санал хүргүүлнэ.	№4.1.9 кодтой “Ачаа тээвэрлэлтийн аюулгүй байдлыг шалгах хяналтын хуудас”, №4.1.10 кодтой “Нийтийн	2025.01.02 2025.05.31	100

	боловсруулахад санал өгөх	-Саналын тоо	санал өгсөн		тээврийн үйлчилгээний байгууллагыг шалгах хяналтын хуудас", №4.1.15 кодтой "Нийтийн тээврийн үйлчилгээний автотээврийн хэрэгслийг шалгах хуудас"-т 3 төрлийн 14 санал хүргүүлсэн.		
4	Арга хэмжээ 1.4. Хяналт шалгалтын хяналтын хуудсыг цахимжуулах хэрэглээний /application/ нэвтрүүлсэн программыг бүрэн ашиглах.	Хяналт шалгалтад ашигласан хяналтын хуудсыг 100 хувь цахимд бүртгэсэн байна.	Хэрэглээний /application/ программыг ашиглаж, хэрэглэж эхэлсэн.	Хяналт шалгалтын мэдээллийг шилэн хяналтын системд бүрэн оруулсан байна.	2025 оны эхний хагас жилд хяналт шалгалт хийхээр батлагдсан 4 объектод төлөвлөгөөт шалгалт хийж, шалгалтын баримт бичгийг шилэн хяналтын системд бүрэн оруулж "Хяналт хийсэн" төлөвт шилжүүлсэн. Урьдчилан сэргийлэх 1 шалгалт, төлөвлөгөөт бус 3 шалгалтын мэдээллийг шилэн хяналтын системд бүрэн оруулж, "Хяналт хийсэн" төлөвт оруулсан байна.	2025.01.02 2025.12.31	100
Зорилт 2. "Иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, аюулгүй байдлыг хангах, ослоос урьдчилан сэргийлж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах."							
5.	Арга хэмжээ 2.1. Их дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 10 объектод төлөвлөгөөт хяналт шалгалт хийх.	10 объектод хяналт шалгалт хийсэн байна	2024 онд 10 объектод төлөвлөгөөт шалгалт хийсэн	7 объектод төлөвлөгөөт шалгалт хийсэн байна	Тайлант хугацаанд 7 объектод шалгалт хийхээр төлөвлөсөн бөгөөд зорчигч тээврийн үйлчилгээ эрхэлдэг 2, ачаа тээвэрлэгч 2 аж ахуйн нэгжийн нийт 4 объектод төлөвлөгөөт шалгалт хийсэн. Зэвсэгт хүчний 256-р анги автобусаар хот орчмын зорчигч тээвэрлэх үйлчилгээндээ хяналт шалгалт хийлгэхгүй тухай 137 тоот албан бичиг ирүүлсэнийг ЗТЯ-ны Салбарын хяналтын газарт уламжилсан бөгөөд шалгалт хийгдээгүй байна. Дэлгэрэх индустриал ХХК-ийн 2 объектод /хот хоорондын зорчигч тээврийн үйлчилгээ болон хүнсний эмзэг бүтээгдэхүүн тээвэрлэлтийн үйл ажиллагаанд/ 06 дугаар сард шалгалт хийгдэхээр батлагдсаны дагуу шалгалт хийгдэж байна. Төлөвлөгөөт шалгалтад Арвайхээр нийтийн тээвэр, гэрэлтүүлэг ОНӨААТҮГ-ын хотын доторх нийтийн	2025.03.03 2025.12.31	80

					зорчигч тээврийн үйл ажиллагаа, Онги ус суваг ТБОНӨО ХХК-ийн ундны ус, бохир ус тээвэрлэх үйл ажиллагаа, Бат эргэлдэх хүрд хоршооны хот хоорондын зорчигч тээврийн үйл ажиллагаа, АЗЗАН ТӨХК-ийн Өвөрхангай Хархорин сум дахь салбарын ачаа тээвэрлэх үйл ажиллагааг хамруулсан. Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/74 дүгээр тушаалаар баталсан хяналтын хуудсуудаар шалгаж, эрсдэл үүсэх магадлал, хууль сахин мөрдөлтийн түвшинг тодорхойлж ажилласан. Шалгалтанд нийт 24 тээврийн хэрэгсэл (автобус 7, ачаа тээврийн 9, суудлын автомашин 8) хамрагдсан байна. Шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулахаар 04-26-01/057/15, 04-26-01/057-16, 04-26-01/057/28, 04-26-02/058-34 дугаартай албан шаардлагуудыг хүргүүлсэн. Онги ус суваг ТБОНӨО ХХК-ийг Зөрчлийн тухай хуулийн 14.6 дугаар зүйлийн 5 дахь хэсгийг үндэслэн 200 нэгж буюу 200000 төгрөгөөр торгох шийтгэлийн арга хэмжээ авч ажилласан. 2025 оны эхний хагас жилд хийх төлөвлөгөөт шалгалт Зам, тээврийн сайдын 2025 оны А/10 дугаар тушаалаар батлагдсан жагсаалтын дагуу хийгдэж байна.		
6.	Арга хэмжээ 2.2. Хяналт шалгалтанд хамрагдсан аж ахуй нэгж, байгууллагад өгсөн албан шаардлагын хүрээнд гүйцэтгэлийн хяналт шалгалт хийх.	Албан шаардлагын хүрээнд гүйцэтгэлийн хяналт шалгалт хийнэ	2024 онд 4 объектод гүйцэтгэлийн хяналт хийсэн	Боловсруулсан албан шаардлагын хүрээнд эхний хагас жилд 1 объектод гүйцэтгэлийн шалгалт хийсэн байна	Тайлант хугацаанд нийт 7 албан шаардлага боловсруулан холбогдох аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагуудад хүргүүлсэн. Үүнээс 1 аж ахуйн нэгж, байгууллагад хүргүүлсэн албан шаардлагын биелэлтэд гүйцэтгэлийн шалгалт хийсэн. Албан шаардлагын хэрэгжилт 82.5%-тай байна.	2025.04.01 2025.12.31	100

7	Арга хэмжээ 2.3. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл гомдлын хүрээнд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх.	Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн хувь Зөрчил арилгалтын хувь	2024 онд төлөвлөгөөт бус шалгалт хийж, илэрсэн зөрчилд шийтгэлийн арга хэмжээ тооцож, албан шаардлага хүргүүлэн зөрчлийг 100% арилгуулж ажилласан.	Өргөдөл гомдлыг 100 хувь шийдвэрлэсэн байна. Зөрчил арилгалтын хувь 70-аас багагүй байна.	Хот хоорондын жолооч нараас аймгийн Засаг даргад ирүүлсэн өргөдөлийн дагуу шийдвэрлэх ажиллагаа явуулж, шалгалтын тухай мэдээллийг илтгэх хуудсаар нэгжийн даргад мэдэгдэж, холбогдох этгээдэд 3-3/304 тоот албан бичгээр хариу хүргүүлж ажилласан. Өргөдөл гомдлын дагуу хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил 100% арилсан байна. Салбарын хяналтын газрын даргын баталсан 04/21 дугаартай төлөвлөгөөт бус шалгалт хийх тухай удирдамжийн хүрээнд Дашваанжил ХХК-ийн Арвайхээр сум дахь АХЦС-12 салбар, Горгаз ХХК-ийн Арвайхээр сум дахь АХЦС-23 салбар, Горгоз ХХК-ийн Хархорин сум дахь АХЦС-24 салбаруудын баллонтай шахсан хий тээвэрлэх үйл ажиллагаа, тээврийн хэрэгслийн ашиглалтын нөхцөл байдлыг Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/74 дүгээр тушаалаар баталсан хяналтын хуудсуудаар шалгаж, эрсдэл үүсэх магадлал, хууль сахин мөрдөлтийн түвшинг тодорхойлж ажилласан. Шалгалтад баллонтай шахсан хий тээвэрлэхээр тоноглогсон 3 автомашин хамрагдсан. Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар Дашваанжил групп ХХК-ийн захирал Н.Баатаржавд 04-26-01/057-19 дугаартай албан шаардлага, Горгаз ХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Цэрэнноровт 04-26-01/057-25, 04-26-01/057-26 дугаартай албан шаардлагуудыг тус тус хүргүүлж ажилласан. Албан шаардлагын биелэлт тооцох хугацаа болоогүй учир гүйцэтгэлийн шалгалт хийгдээгүй байна.	2025.01.02 2025.12.31	100
---	--	---	--	--	---	--------------------------	-----

					Төлөвлөгөөт бус хяналт шалгалтын мэдээллийг шилэн хяналтын системд тухай бүрд нь оруулж "Хяналт хийсэн" төлөвт шилжүүлж ажилласан байна.		
8	Арга хэмжээ 2.4. ЗТЯ-ны СХГ-аас ирүүлсэн удирдамжийн дагуу авто тээврийн чиглэлээр урьдчилан сэргийлэх шалгалт хийх.	Шалгалт хийсэн объектын тоо Илрүүлсэн зөрчил, арилгалтын хувь Арга хэмжээний биелэлт	2024 онд ЗТЯ-ны СХГ-аас ирүүлсэн удирдамжийн дагуу урьдчилан сэргийлэх шалгалт хийсэн	Удирдамжийн хүрээнд шалгалтыг бүрэн хийсэн байна	Салбарын хяналтын газрын даргын баталсан 04/04 дугаартай удирдамжийн хүрээнд Өвөрхангай аймгийн такси үйлчилгээ эрхлэгчдийн холбоо ТББ-ын үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх шалгалт хийж, такси үйлчилгээг тусгай зөвшөөрлийн хүрээнд гүйцэтгэх болсонтой холбогдож үйлчилгээнд явуулж байгаа тээврийн хэрэгсэлүүд нь Автотээврийн тухай хуульд заасан шалгуурыг хангахгүй байгаа талаар мэдээлэл хийж чиглэл өгч ажилласан. Төлөөлөл болгон 8 тээврийн хэрэгсэл шалгаж ЗДТГ-ын даргад илтгэх хуудсаар мэдээлсэн.	2025.01.02 2025.12.31	100
9	Арга хэмжээ 2.5. Зөрчлийн хэргийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шалган шийдвэрлэх.	Зөрчил шалган шийдвэрлэсэн тоо, хэрэг шийдвэрлэлтийн хувь	2024 онд 3 зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж, шийдвэрлэлтийг 100 хувь хангасан.	Хууль тогтоомжийн хүрээнд зөрчлийг шалган шийдвэрлэж, хэрэг шийдвэрлэлтийг 100 хувь хангуулсан байна.	Тайлант хугацаанд Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хүрээнд 1 удаа зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж, Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтыг үндэслэн 1 аж ахуйн нэгж, байгууллагад 200 нэгж буюу 200000 төгрөгөөр торгох шийтгэлийн арга хэмжээ тооцсон. Зөрчлийн хэргийг прокурорт хянуулж, холбогдох этгээдэд хариу мэдэгдэж ажилласан. Хэрэг шийдвэрлэлт 100%, торгуулийн мөнгийг Төрийн сангийн 100100000988 тоот дансанд бүрэн төвлөрүүлсэн.	2025.01.02 2025.12.31	100
Зорилт 3. Салбарын яам, салбарын хяналтын газар, холбогдох бусад газраас зохион байгуулсан сургалт зөвлөгөөд хамрагдах							
10	Арга хэмжээ 3.1 ЗТЯ, Салбарын хяналтын газраас зохион байгуулагдсан сургалт, зөвлөгөөнд хамрагдах.	Зохион байгуулсан арга хэмжээний тоо Арга хэмжээтэй холбоотой үйл	2024 онд хяналтын улсын байцаагчдын 1 удаагийн цахим	Зохион байгуулсан тоогоор	ЗТЯ-ны СХГ-аас зохион байгуулсан улсын /ахлах/ байцаагчдыг чадавхижуулах танхимын сургалтад хөтөлбөрийн дагуу бүрэн хамрагдсан.	2025 оны 03 сард	100

		ажиллагаа зохион байгуулсан тоо	сургалтанд хамрагдсан.				
--	--	---------------------------------------	---------------------------	--	--	--	--

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
1.	Арга хэмжээ 1. Шинээр худалдан авч байгаа тээврийн хэрэгслийг хүлээж авах комиссын гишүүнээр болон акталж өмчөөс хасах комисст ажиллах	Хууль тогтоомж, дүрэм, журмын хүрээнд ажиллах	Комисс ажилласан тоогоор	Комисс ажилласан тоогоор	Шинээр авч байгаа тээврийн хэрэгслийг хүлээж авах комисст 3 удаа, өмчөөс хасах комисст 2 удаа ажилласан.	2025.01.02 2025.12.31	100


Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)			
	1	2	3	4	5	6	7	
1	Арга хэмжээ 1. Шинээр гарсан болон өөрчлөлт орсон хууль, тогтоомж, дүрэм, журам, стандартыг судлах	Хууль тогтоомж, дүрэм, журам, стандартыг судлах	100	50	"Автотээврийн хэрэгслийн ангилал. Техникийн байдалд тавигдах ерөнхий шаардлага" MNS4598:2025 стандартыг судалж, стандартад орсон өөрчлөлтүүдийг хяналтын хуудаст тусгаж, хяналт шалгалтад хэрэглэж байна.	2025.01.02 2025.12.31	100	
2	Арга хэмжээ 2. Холбогдох бусад газраас зохион байгуулагдсан сургалт, зөвлөгөөнд хамрагдаж мэргэжлийн мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх	Мэргэжлийн мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх	100	50	Улсын Ерөнхий прокурорын газраас зохион байгуулсан сургалтад оролцсон. Аймгийн Прокурорын газраас зохион байгуулсан эрх бүхий албан тушаалтнуудын зөвлөгөөнд хамрагдсан.	2025 оны 02 сард 2025 оны 05 сард	100%	
3	Арга хэмжээ 3. Аж ахуйн нэгж,	Үндэсний	Үндэсний	Үндэсний	Үндэсний монгол бичгээр	2025.01.02	100	

байгууллагуудад хүргүүлэх албан тоотыг хос бичгээр гаргаж хүргүүлэх	монгол бичгээр албан тоот боловсруулж сурах	монгол бичгээр унших дунд, бичих дунд.	монгол бичгээр унших, бичих чадвараа сайжруулна. Албан тоотыг хос бичгээр боловсруулахад суралцана.	унших, бичих чадвараа бие даан дээшлүүлж байна. ЗДТГ-ын албан хаагч нарын үндэсний монгол бичгээр унших, бичих чадварын түвшинг шалгах шалгалтад хамрагдсан. Албан тоотыг хос бичгээр боловсруулахад суралцаж байна. Үндэсний монгол бичиг рүү хөрвүүлдэг программыг компьютерт суулгуулаад байна.	2025.12.31	
---	---	--	---	--	------------	--

ТАЙЛАН ГАРГАСАН:

Автотээврийн хяналтын улсын
байцаагч

 / Б.Цэндсүрэн /

2025 оны 06 дугаар сарын 03-
ны өдөр